



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/346

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан Намсрайгомбын Хишигбаатар газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурьдсанаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан байгууллагатай гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Ё.Мөнх-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан Баатарсүрэнгийн Мягмарсүрэн-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний А/95 дугаар захирамжийн Намсрайгомбын Хишигбаатар-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ӨНХТӨР

2325310578

D:\disk\bichig hereg/ zahiramj/



сумын Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн
А/376 дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлсэн болон шилжүүлэн авсан иргэний жагсаалт

Шилүүлэн авч буй АА-н нэгж, иргэний нэр	Регистрийн дугаар	Газрын хэмжээ /га/	Хугацаа /жил/	Газрын байршил	Зориулалт	Нэгж талбарын дугаар	Шилжүүлсэн АА-н нэгж, иргэний нэр	Шилжүүлсэн үндэслэл
Жонон Баатарсайхан Мягмарсүрэн	CP89100308	1	9	2-р баг, Баахнаа өвөр	Хаваржаа	2314003370	Гучид Намсрайгомбо Хишигбаатар	Өөрийн хүсэлтээр
Дүн		1						